**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 04 сарын 12 өдөр    Дугаар А/35    Улаанбаатар хот

Сүрьеэгийн эрт илрүүлгийг зохион байгуулах тухай

Засгийн газрын 2017 оны "Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр батлах тухай" 11 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2017 оны "Сүрьеэгийн тусламж үйлчилгээг сайжруулах зарим арга хэмжээний тухай" А/306-р тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Сүрьеэгийн өрхийн болон ойрын хавьтлыг үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулах идэвхтэй эрт илрүүлэгт ажиллах багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Харьяа хүүхдийн байгууллага дээр зохион байгуулагдах эрт илрүүлгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцон, шаардлагатай эмч сувилагч нарыг ажиллуулах, холбогдох судалгаа мэдээллийг түргэн шуурхай гаргаж өгөх, ажиллах өрөө, нөхцлийг сургуультай хамтран бэлэн байдлыг хангуулж хамтран ажиллахыг Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Илрүүлгийн үйл ажиллагаанд шаардлагатай сувилагч мэргэжилтний ажлыг зохицуулан, тасаг нэгжээс дайчлан ажиллуулахыг Поликлиникийн эрхлэгч /Д.Молор-Эрдэнэ/, Сувилахуйн албаны дарга /Б.Халиунгэрэл/ нарт даалгасугай.

4. Илрүүлгийн багийн үйл ажиллагаа, цэр зөөвөрлөлтийг цаг хугацаанд нь хүргүүлэх унаагаар шуурхай хангаж ажиллахыг Аж ахуй, нийтлэг үйлчилгээний албаны дарга /П.Буяндаваа/-д үүрэг болгосугай.

5.Илүү цагаар ажилласан эрт илрүүлгийн багийн бүрэлдэхүүний цалинг холбогдох журмын дагуу олгохыг ерөнхий нягтлан бодогч /Д.Хишигсүрэн/-д зөвшөөрсүгэй.

6.Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга /Б.Лувсанням/-д даалгасугай.

ДАРГА    Э.БОДЬЦЭЦЭГ

ТТБ2350ж0120262

Б 170 70 0279

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн даргын
2018 оны 04 сарын 12-ны өдрийн
А/35 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

## ЭРТ ИЛРҮҮЛЭГТ АЖИЛЛАХ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

| | |
|---|---|
| Л.Нарангэрэл | Сүрьеэ диспансерийн зохицуулагч |
| Ө.Ариунжаргал | Тархвар судлаач |
| Э.Пагамсүрэн | Сүрьеэ диспансерийн эмч |
| Б.Отгонхүү | Сүрьеэ диспансерийн эмч |
| Ц.Нарантуяа | Сүрьеэгийн дүн бүртгэгч бага эмч |
| Д.Мэнджаргал | Сүрьеэгийн сувилагч |
| Х.Гүлжан | Сүрьеэгийн эмийн сувилагч |
| Т.Нарантуяа | Сувилагч |

Шаардлагатай тохиолдолд нэмэлтээр ӨЭМТ, тасаг нэгжээс эмч, сувилагч нэмэлтээр ажиллуулна.

| | | | | |
|---|---|---|---|---|
| 9 | Үзлэгт ажиллах багт шаардлагатай хамгаалах нэг удаагийн бээлий, малгай, маск, спирт, шприц 1гр, хог хаягдлын уут, аюулгүй хайрцаг, гар халдваргүйтгэх уусмалыг 1800 хүн үзлэгт хамруулахад хүрэлцэхүйц хэмжээгээр захиалж, бэлэн байдлыг хангах | 2018 оны 04 сарын 11 | Сүрьеэ диспансер | Ерөнхий нягтлан, эмийн сан |
| 10 | Рентген шинжилгээний журнал 1ш, асуумжийн хуудас1700 ш, бүртгэлийн маягт, бичгийн цаасыг захиалж бэлтгэх | 2018 оны 04 сарын 11 | Тархвар судлаач | Ерөнхий нягтлан, аж ахуйн нярав |
| 11 | Урьдчилан сэргийлэх үзлэгийн дүнг тооцон ажиллаж, тайланг НЭМГ, ХӨСҮТ-д хүргүүлэх | 2018 оны 05 сарын 20 | ЭМТөвийн сүрьеэ диспансар ЭМТөвийн тархвар судлаач | ХӨСҮТ-ийн сүрьеэ тандалтын алба |